

ТӨМӨР ЗАМААР ЗОРЧИГЧ, ТЭЭШ, АЧААН ТЭЭШ ТЭЭВЭРЛЭХ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

I БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл: Зорилго

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Төмөр замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд тээвэрлэлтийн үйл ажиллагааны нийтлэг үндсэн зарчимд тулгуурлан зорчигч, тээш, ачаан тээшийг түргэн шуурхай, бүрэн бүтэн тээвэрлэхэд оршино.

1.2. Хамрах хүрээ: Орон нутгийн зорчигч тээврийн харилцаанд оролцогч төмөр замын байгууллага болон зорчигч, тээш, ачаан тээш илгээгч ба хүлээн авагч нарын хоорондын харилцааг зохицуулна.

II БҮЛЭГ

Зорчигч тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл

2 дугаар зүйл. Зорчих тасалбар худалдах газрын үйл ажиллагаа.

2.1. Тасалбар худалдах газар нь тасалбар худалдах үйл ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулна.

2.1.1. Тасалбарыг доор заасан хугацаанаас эхлэн худалдана.

а) Урьдчилсан захиалгат тасалбарыг хуваарьт галт тэрэг явахаас 2 сарын өмнө,

б) Өдөр тутмын тасалбарыг тухайн өдрийн тасалбар худалдах газрын нээгдэх цагаас;

в) Завсрын өртөөнд галт тэрэг ирэхээс 1 цагийн өмнө тус тус худалдана.

2.1.2. Галт тэрэг хөдлөхөөс 15 минутын өмнө тасалбар худалдах ажиллагааг зогсооно. Тасалбар худалдах газрын байршлаас хамаарч эрх бүхий ажилтан дээрх хугацааг өөрчилж болно.

2.1.3. Тасалбар худалдах газартай өртөө, зөрлөгөөс галт тэргэнд тасалбаргүй суусан зорчигчид тасалбар худалдах явуулын нярав /цаашид “явуулын нярав” гэх/ тасалбарыг нэмэгдэлтэй тарифаар худалдана. Нэмэгдлийн хэмжээг төмөр замын байгууллагын дарга тогтооно.

2.1.4. Хот, дүүргийн галт тэрэгний тасалбар худалдах газрын ажиллах цагийн хуваарийг галт тэрэгний аялах хуваарьтай уялдуулан эрх бүхий ажилтан тогтооно.

2.2. Галт тэргээр зорчих тасалбарт явах хүрэх өртөө, галт тэрэг, вагон, зорчих байрын дугаар, явах огноо, цаг минут, зорчигчийн тоо, тариф үнэлгээ, зорчигчийн нэр, регистрийн дугаар, олгосон огноо, цаг минутыг тус тус бичнэ.Тасалбарын ар талд зорчигчид зориулсан санамж байна.Тухайн тээвэрлэгчээс нийтэд зарласан нэмэлт үйлчилгээний мэдээлэл байж болно.

2.3. Маягтын бүсийн тасалбарыг галт тэрэгний аяллын явцад олгох бөгөөд загварыг тээвэрлэгч тогтооно.

2.4. Маягтын бүсийн тасалбарын бичвэрийг баллах, засварлахыг хориглоно.

2.5. 5-12 хүртэлх насны хүүхдэд насанд хүрсэн хүний нэгэн адил суух байр бүхий хөнгөлөлттэй зорчих тасалбар олгоно.

2.5.1. Зорчигч 0-4 насны 3 хүртэлх тооны хүүхдийг тусгай байр эзлүүлэхгүй авч зорчих бол тэдгээр хүүхдийг үнэ төлбөргүй аялуулна. Тасалбарт хүүхдийн тухай мэдээлэл оруулахыг тээвэрлэгч хариуцна.

2.5.2. Зорчигчийн хамт 5 хүртэлх насны 3-аас дээш тооны хүүхэд зорчвол 4 дэх хүүхдээс эхлэн хүүхдийн тасалбар худалдан авна.

2.5.3. 7 хүртэлх насны хүүхдийг насанд хүрсэн харгалзах хүнгүйгээр зорчигчийн галт тэргэнд явахыг хориглоно.

2.5.4. Зорчигчийн хамт яваа 5-12 хүртэлх насны 1 хүүхдийг унтлагын байр эзлэхгүйгээр авч явахыг зөвшөөрнө.

2.5.5. Насанд хүрсэн хүнтэй хамт яваа 5-12 насны 2 хүүхдийн дунд унтлагын 1 байр эзлэхийг зөвшөөрнө.

2.6. Өртөө, буудлын дотор болон гадна талд зорчигчдод зориулсан мэдээллийг хууль, тогтоомжид заасны дагуу байршуулна. Мэдээлэл хүргэх хэлбэрийг тээвэрлэгч өөрөө тогтооно.

2.7. Галт тэргээр зорчих тасалбар нь тээвэрлэгч, зорчигч хоёрын хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох бичиг баримт бөгөөд батлагдсан загварын дагуу үйлдэгдсэн байна.

2.8. Зорчих тасалбарыг бэлэн ба бэлэн бус тооцоо эсвэл тогтоосон журмын дагуу зээлээр олгож болно.

2.9. Зорчигчийн вагоны байрны тооноос илүү тасалбар худалдахыг хориглоно.

2.10. Зохион байгуулалттайгаар бүлгээр аялах зорчигчдын урьдчилсан захиалгыг өртөө ба буудлын эрх бүхий ажилтан хянаж тасалбарыг олгоно.

2.11. Нийтийн вагоны тасалбар худалдаж авсан зорчигч хүсвэл явах чиглэлийнхээ дагуу унтлагын байрны нэмэгдэл төлж, очих өртөө хүртлээ зорчиж болно. Харин нэмэгдлийг шилжин суух эхний өртөөнөөс авах ба шууд харилцааны вагонд бол уг вагон хүрэх өртөө хүртэл авна.

2.12. Зорчигч тасалбараа үрэгдүүлсэн, гээгдүүлсэн тохиолдолд тээвэрлэлтийн гэрээ байгуулсан нь нотлогдвол нэмэлт үйлчилгээний хураамж төлж тасалбарыг дахин авч

болно. Зорчих тасалбарт нэр нь бичигдсэн зорчигч уг тасалбараар үйлчлүүлнэ. Зорчих тасалбарыг бусдад дамжуулахыг хориглоно.

2.13. Тасалбар худалдах газар нь доорх тохиолдолд зорчих тасалбар худалдахаас татгалзах эрхтэй:

2.13.1. Галт тэргэнд чөлөөтэй байр байхгүй,

2.13.2. Асран хамгаалагчгүй дараах иргэн: хүнд өвчтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн, мансуурсан этгээд,

2.13.3. Биеийн байцаалтгүй хүн.

3 дугаар зүйл. Зорчих тасалбарын хүчинтэй хугацаа

3.1. Зорчих тасалбар нь тасалбарт тэмдэглэсэн хугацаанд, аялал эхлэх өртөөнөөс дуусах өртөө хүртэл тухайн галт тэрэг, вагонд хүчинтэй.

3.2. Өртөө буудлын эрх бүхий ажилтан буюу тасалбар худалдах газрын эрхлэгч тасалбарын хугацааг доорх тохиолдолд сунгах эрхтэй:

3.2.1. шилжин суух галт тэргэнд чөлөөтэй байргүй бол дараагийн галт тэргэнд байр авах хүртэлх хугацаанд;

3.2.2. зорчих ёстой галт тэрэг нь шилжин суух өртөөнд батлагдсан хуваариас хожимдож ирсэн бол аяллаа үргэлжлүүлэх хүртэлх хугацаанд;

3.2.3. зорчигчид хүндэтгэн үзэх шалтгаан тохиолдсоныг тодорхойлсон бичиг баримтын дагуу;

3.2.4. галт тэргэнд (хот, дүүргийнхээс бусад) зорчих тасалбартай боловч эзлэх ёстой байрыг олгоогүй бол зохих байр олгох бололцоотой дараагийн галт тэргээр явах хүртэл;

3.2.5. зорчигч хоорондын өртөө, зөрлөгт түр буух бол 10-аас дээшгүй хоногоор сунгаж болох ба тасалбарт сунгасан тухай тэмдэглэл хийнэ.

3.2.6 Бусад тохиолдолд зорчих тасалбарын хүчинтэй хугацааг сунгахгүй.

4 дүгээр зүйл. Төлбөрийг буцааж олгох

4.1. Төмөр замын байгууллага дараах тохиолдолд ашиглаагүй зорчих тасалбар, тээвэрлээгүй тээш, ачаан тээшийн тээврийн төлбөрийг нотлох баримт гарган, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн өгсний дараа тээвэрлэгчийн эрх бүхий ажилтны шийдвэрээр зохих журмын дагуу буцааж олгож болно:

а. Галт тэргэнд зорчих тасалбарын дагуу зохих байрыг олгоогүй тохиолдолд зорчигчийн шаардлагаар явах өртөөний холбогдох ажилтан акт үйлдэн, зорчигчоос хураасан бүх төлбөрийг зорчигчид буцааж өгч, актын ар талд гарын үсэг зуруулна.

б.Зорчигч зорчин явж чадахгүйд хүрч, галт тэрэг хөдлөхөөс 24 цагийн өмнө зорчих тасалбар дээр төмөр замаар тэмдэглэл хийлгэсэн тохиолдолд нийтийн вагонд бол тээврийн хөлс, тасалгаат вагонд бол тээврийн хөлс ба унтлагын байрны хөлсний хамт, галт тэрэг хөдлөхөөс 24 цагийн дотор тэмдэглэл хийлгэсэн тохиолдолд энэхүү дүрмийн 4.2-т заасан суутгал хийлгэж тасалбарын төлбөрийг буцааж авах эрхтэй.

в. Галт тэрэгний хөдөлгөөн ямар нэг шалтгаанаар саатсан үед зорчигч аяллаа үргэлжлүүлэхээс татгалзвал төмөр замын байгууллага нь зорчигчийн мэдүүлгийн үндсэн дээр зорчоогүй зайд ноогдох тээврийн хөлсийг буцааж олгоно. Үүнийг зорчигчоос гаргасан бичгэн мэдүүлгийн үндсэн дээр шийдвэрлэнэ.

г.Өвчтэй ба хүндэтгэх шалтгааны улмаас зорчигч аяллаа бүр зогсоовол зорчоогүй зайд ногдох тээврийн хөлсийг буцааж олгоно.

д.Дээр заасан төлбөрийн буцаалтыг дурын тасалбар худалдаалах газраас буцааж олгоно.

4.2. Зорчигч тээвэрлэлтийн гэрээг цуцалсан тохиолдолд дор дурдсанаас ихгүй үйлчилгээний хөлсийг суутган авна:

а. Галт тэрэг аялахаас өмнө 2-24 цагийн дотор буцаавал нийт төлбөрийн 10 хувь,

б. Галт тэрэг аялахаас өмнө 2 хүртэл цагийн дотор буцаавал нийт төлбөрийн 20 хувь,

в. Галт тэрэг хөдөлснөөс хойш 30 хүртэл минутын дотор буцаавал нийт төлбөрийн 50 хувийг тус тус суутгаж олгоно. /Тэмдэглэл хийсэн хугацааг баримтлан буцаалт хийнэ./

5 дугаар зүйл. Зорчих нөхцөл

5.1. Зорчигч тасалбар худалдах газартай өртөөнөөс зорчих тасалбар авч галт тэргэнд суух ба нийтийн вагонд зорчиж буй зорчигч тасалбараа аяллын хугацаа дуустал өөртөө хадгалж, шалгагч (эрх бүхий албан тушаалтан)-ийн шаардлагаар үзүүлэх үүрэгтэй.

5.2. Зорчигчийг вагонд суулгахаас өмнө вагоны үйлчлэгч зорчих тасалбарын хүчинтэй эсэх, биеийн байцаалттайгаа тохирч буй эсэх, асран хамгаалагчгүй согтуурсан, мансуурсан, дүрэмд заасан тогтоосон хэмжээний гар тээштэй эсэхийг шалгах бөгөөд, зөрчсөн нөхцөлд галт тэргэнд оруулахгүй. Энэ тохиолдолд зорчигч тээвэрлэлтийн гэрээг зөрчсөнд тооцож тээвэрлэлтийн гэрээг цуцлан тасалбарыг хурааж авна.

5.2.1. Галт тэрэг 2 хүртэл минутын зогсолттой өртөө, зөрлөгт зорчигчийг галт тэрэгний аль ч вагонд оруулж болно.

5.2.2. Вагоны үйлчлэгч зорчигчид зорчих тасалбарт заасан вагондоо суухад нь зохих туслалцаа үзүүлнэ.

5.3. Тасалбар худалдах газар зорчих тасалбарыг буруу үйлдсэн буюу вагонд чөлөөтэй байргүй үед зорчигчдод зорчих тасалбар олгосон зорчих байр давхардуулан бичсэн байвал галт тэрэгний дарга, вагоны үйлчлэгч, тасалбар худалдах газар эрх бүхий ажилтны оролцоотойгоор галт тэргэнд байр олж өгөх буюу алдааг залруулах арга хэмжээ авна. Хэрэв зорчих тасалбар буруу олгосон нь аяллын явцад илэрвэл галт тэрэгний дарга, вагоны үйлчлэгч, явуулын нярав хамтран акт үйлдэн холбогдох арга хэмжээ авна.

5.4. Төмөр замын ажилтны буруугаас зорчигч тасалбарт зааснаас өөр чиглэлийн галт тэргэнд суусан эндүүрэл гарвал түүнд торгууль ногдуулахгүй бөгөөд ойролцоох өртөөнд буулгаж үндсэн өртөө хүртэл үнэгүй зорчихыг зөвшөөрнө. Буруутай ажилтанд төмөр замын байгууллага холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

5.5. Зорчигч нь зорчих тасалбарт заасан байрыг аяллын хугацаанд ашиглах эрхтэй.

5.6. Завсрын өртөөнд буух зорчигч уул вагонд цааш аяллаа үргэлжлүүлэхийг хүсвэл энэ тухайгаа вагоны үйлчлэгчид мэдэгдэх ба явуулын нярав сул байр байгаа эсэхийг тодруулсны дараа цааш зорчих хөлсийг нэмж авна.

5.7. Вагоны үйлчлэгч зорчигчдод галт тэрэг ямар өртөө, зөрлөгт хүрэлцэн ирж буйг урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Зорчигч буух буюу шилжин суух өртөөнд буухгүй өнгөрсөн тохиолдолд дахин зорчих тасалбар авна. Хэрэв зорчигч өөр чиглэлийн галт тэргээр зорчихоор болсон тохиолдолд өмнө худалдаж авсан тасалбараа эргүүлэн өгч, төлбөрийн зөрүүг төлж шинэ тасалбар авна.

5.8. Зорчигч галт тэрэгнээс хоцорвол энэ тухайгаа тасалбар худалдах газарт мэдэгдэж тэмдэглэл хийлгэнэ. Хүндэтгэх шалтгаанаар хоцорсон бол энэ дүрмийн 3.2-т заасны дагуу сунгалт хийж, зорчигчийг дараагийн галт тэргэнд суулгана. Бусад тохиолдолд зорчих тасалбарыг энэхүү дүрмийн 4 дүгээр зүйлд заасны дагуу буцаалт хийнэ.

5.9. Галт тэрэгнээс хоцорсон зорчигчийн эд юмс нь уг галт тэргэнд явсан бол энэ тухайгаа буудлын дарга эсвэл тасалбар худалдах газрын эрхлэгчид мэдэгдэж, бичгээр хүсэлт гаргана. Төмөр замын байгууллага нь зорчигчийн эд юмсыг хамгаалах арга хэмжээ авч, хүсэлтийн дагуу хүлээлгэн өгөх ба үйлчилгээний хөлсийг тарифын дагуу уул зорчигчоор төлүүлнэ.

5.10. Вагоны үйлчлэгч зорчигч галт тэрэгнээс хоцорсныг мэдвэл энэ тухай галт тэрэгний дарга, явуулын нярав нарт мэдэгдэж, уг зорчигчийн орхисон эд юмсыг галт тэрэгний дарга, цагдаагийн ажилтан, үйлчлэгч болон хөндлөнгийн гэрчийн этгээдийн хамт акт үйлдэн хадгалж, хамгаална.

5.11. Шууд харилцааны вагон бүхий галт тэрэг хуваарьт цагаас хоцорч, уг вагоныг залган аяллыг цааш үргэлжлүүлэх галт тэрэг явснаас хойш ирсэн бол буудлын дарга зорчигчдыг аль болохоор эхний ээлжид явах арга хэмжээг авна. Зорчигч унтлагын байр худалдаж авсан бол зэрэглэл бууруулалгүй сольж өгнө.

5.12. Зорчигч зорчих галт тэрэгнээсээ өмнө аялах галт тэргээр зорчих болсон тохиолдолд өмнө нь худалдаж авсан тасалбараа тасалбар худалдах газарт буцааж өөрийн явах галт тэргэнд дахин тасалбар худалдан авч зорчино.

6 дугаар зүйл. Зорчих тасалбарыг буруу ашиглах

6.1. Нийтийн вагоноор зорчих тасалбартай зорчигч унтлагын байрны нэмэгдлийн зөрүүг төлөхгүйгээр унтлагын байранд буюу дээд зэрэглэлийн вагонд суусан бол зорчигчийг тасалбарт заасан байрандаа суухыг шаардана. Хэрэв суусан вагонд нь чөлөөтэй байр байвал зохих нэмэгдлийг төлүүлснээр тухайн байранд зорчихыг зөвшөөрнө. Харин зорчигч тарифын зөрүүг төлөхөөс татгалзвал холбогдох хууль тогтоомжийн дагуу торгууль ногдуулж, тарифын зөрүүг төлүүлнэ.

6.2. Зорчигч нь өөр хүний нэр бүхий тасалбар, хугацаа дууссан эсвэл хуурамч тасалбараар зорчвол тасалбарыг хүчингүйд тооцож, холбогдох хууль тогтоомжийн дагуу торгууль ногдуулж, дахин тасалбар авахыг шаардах ба татгалзвал галт тэрэгнээс буулгана.

7 дугаар зүйл. Зорчих тасалбар үйлдэх үед гарах зөрчлийг залруулах

7.1. Төмөр замын ажилтны буруугаас бүрэн бус тэмдэглэл хийгдсэн зорчих тасалбар илэрвэл хүчингүйд тооцон хураан авч, энэ тухай акт үйлдэн зорчигчид шинээр тасалбар олгох ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ:

7.1.1. Тасалбарыг солих тухай актыг галт тэрэгний дарга, байцаагч үйлдэх ба харин галт тэрэг сэлгэн суух өртөөнд нэгэнт ирсэн, зорчигч аяллаа цааш үргэлжлүүлэх бол өртөө болон буудлын дарга акт үйлдэнэ.

7.1.2. Өртөөний тасалбар худалдах газар эсвэл явуулын нярав нь зохих зэрэглэлийн вагонд төлбөргүйгээр шинэ тасалбар олгох ба хүчингүй болгосон тасалбарыг актад хавсаргана. Тасалбарын ар талд "хураасан тасалбарын оронд олгов" гэсэн тэмдэглэл хийнэ.

7.1.3. Хураагдсан тасалбарт "тээш" гэсэн тэмдэглэлтэй бол түүнийг шинээр үйлдсэн тасалбарт нөхөж бичнэ.

7.1.4. Шинээр олгосон тасалбар ба актад тухайн зорчигчоор гарын үсэг зуруулна.

8 дугаар зүйл. Ашиглагдсан тасалбарыг буцаах

8.1. Тасалгаат болон унтлагын вагоны үйлчлэгч зорчигч буух өртөөндөө хүрэлцэн ирэхийн өмнө тасалбар болон бусад тээврийн бичиг баримтыг эзэнд нь буцааж өгнө.

9 дүгээр зүйл. Зорчигчид үзүүлэх үйлчилгээ

9.1. Унтлагын байр бүхий вагонд тасалбартай зорчигчийн аяллын хугацаа 22.00-06.00 цагийн хооронд бөгөөд 2 цагаас урт үргэлжлэх тохиолдолд цагаан хэрэглэлээр заавал үйлчилнэ.

9.2. Зорчигч цагаан хэрэглэлийг галт тэрэгнээс буухаас 15 минутын өмнө вагоны үйлчлэгчид хураалгана.

9.3. Зорчигч цагаан хэрэглэлийг үрэгдүүлсэн буюу цаашид ашиглах боломжгүй болгож бохирдуулсан тохиолдолд цагаан хэрэглэлийн үнийг 2 дахин нэмэгдүүлж төлнө.

9.4. Вагоны үйлчлэгч нь зорчигчийн хүсэлтээр цай, кофе, цэвэр ус, буцалсан ус, ахуйн хэрэгцээний зүйлс, Wi-Fi болон интернэт үйлчилгээ зэргээр тогтоосон тарифын дагуу үйлчилнэ.

9.5. Хоорондын замд буусан зорчигч тус дүрмийн 10.1-т заасны дагуу аяллаа үргэлжлүүлэхдээ цай, цагаан хэрэглэлийг 9 дүгээр зүйлийг баримтлан худалдан авч, үйлчлүүлнэ.

10 дугаар зүйл. Замд түр буудаллах, шилжин суух

10.1. Зорчигчийн хүсэлтээр зорчих тасалбарын хүчинтэй хугацааг 10-аас дээшгүй хоногоор сунгаж болно. Энэ тохиолдолд зорчигч галт тэрэг ирснээс хойш 30 минутын дотор тус өртөөний тасалбар худалдах газарт очиж зорчих тасалбартаа тэмдэглэл хийлгэж, эрх бүхий ажилтнаар сунгуулна. Зорчигч дээрх хугацааны дотор аяллаа үргэлжлүүлж болох ба энэ тохиолдолд зорчих тасалбараа ердийн журмаар тэмдэглүүлж байр авна.

10.2. Зорчигч хүсвэл аяллын явцад доод зэрэглэлийн вагонд шилжин сууж болох бөгөөд анх төлсөн тээврийн хөлсний зөрүүг буцааж олгохгүй.

10.3. Төмөр замын байгууллагын буруугаас зорчигчийг дээд зэрэглэлийн вагон буюу галт тэргэнд шилжүүлэн суулгах шаардлага гарсан тохиолдолд галт тэрэгний дарга ба ертөөний эрх бүхий ажилтан акт үйлдэж, уг ажлыг зохион байгуулна.

10.4. Энэ дүрмийн 10.3 дугаар зүйлд дурдсан тохиолдолд дээд зэрэглэлийн вагонд шилжүүлэн суулгасан нэмэгдлийг зорчигчоос хураахгүй, харин доод зэрэглэлийн вагонд шилжүүлэн суулгасан бол зорчих тасалбарын үнийн зөрүүг зорчигчид буцааж олгоно. Гэхдээ галт тэргэнд зорчигчийн зорчих тасалбарт тохирсон сул байр гармагц уг зорчигчийг тухайн байранд шилжүүлэн суулгана. Хэрэв зорчигч түүнээс татгалзсан тохиолдолд зорчих тасалбарт нь тохирсон байр эзлэхийг мэдэгдсэн өртөө хүртэл дээд зэрэглэлийн вагонд суулгасан зорчих тасалбарын үнийн зөрүүг төлөхгүй буюу мэдэгдэл өгсөн өртөөнөөс эхлэн дээд зэрэглэлийн вагоноор зорчсоны нэмэгдлийг зорчигчоор төлүүлнэ.

10.5. Салгагдсан вагонд зорчигч цагаан хэрэглэлийн үнэ төлсөн байвал уг вагоны үйлчлэгч акт үйлдэж /галт тэрэгний дарга/ гарын үсэг зурж буудлын тэмдэг дараад нэг хувийг зорчигчид өгөх бөгөөд энэ актыг үндэслэн дараагийн вагонд цагаан хэрэглэлийг үнэгүйгээр олгоно.

10.6. Салгагдсан вагоноос өөр вагонд зорчигчдыг шилжүүлэн суулгахад төмөр замын ажилтан шаардагдах туслалцаа үзүүлэх ба галт тэрэгний дарга нар зорчигчдын аюулгүй байдлыг хангах урьдчилсан арга хэмжээг авсан байвал зохино.

11 дугаар зүйл. Тээвэрлэхээс татгалзах

11.1. Төмөр замын байгууллага дараах тохиолдолд зорчигчийг цааш тээвэрлэхээс татгалзах, зорчигчийг галт тэрэгнээс буулгаж тээвэрлэлтийн гэрээнээс татгалзах эрхтэй:

11.1.1. Зорчигч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан тохиолдолд эрх бүхий этгээдийн оролцоотойгоор

11.1.2. Бусад зорчигчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, гэм хор учруулахуйц зорчигч /сэтгэцийн хүнд өвчтэй зэрэг/ байвал түүнд тусгайлан байр гаргаж өгөх буюу тийм бололцоогүй нөхцөлд зорчигчийг эмнэлгийн байгууллага бүхий өртөөнд галт тэрэгнээс буулгана.

Дээрх шалтгаанаар зорчигчийг галт тэрэгнээс буулгасан тохиолдолд эрх бүхий ажилтан, галт тэрэгний дарга нар холбогдох хүмүүсийг байлцуулан акт үйлдэнэ.

11.2. Энэ дүрмийн 11.1.2-д дурдсан шалтгаанаар галт тэрэгнээс буусан зорчигчийн хүсэлтээр зорчоогүй зайн зорчих тасалбарын үнийн зөрүүг буцааж олгох буюу зорчих тасалбарын хүчинтэй хугацааг сунгах асуудлыг зорчигч буусан өртөө, буудлын эрх бүхий ажилтан шийдвэрлэнэ.

11.3. Хэрэв буусан зорчигч өөрийнхөө тээшийг зорчих тасалбарт заасан өртөө хүртэл илгээхийг зөвшөөрөөгүй тохиолдолд тээшийн тасалбарыг үндэслэн уг зорчигчийн буусан өртөөнд тээшийг олгох ба бололцоогүй бол уг тээшийг очих өртөө хүртэл илгээнэ.

III БҮЛЭГ

Гар тээш тээвэрлэх нөхцөл

12 дугаар зүйл. Гар тээш тээвэрлэх

12.1. Гар тээш нь сав, баглаа, боодлын байдлаас үл хамааран хэмжээгээрээ вагоны гар тээшний байранд хялбар багтах, бусад зорчигчдод саад болохооргүй байх ёстой.

12.2. Зорчигч нь зорчих тасалбараар 36 кг-аас илүүгүй жинтэй, 5-12 хүртэлх насны хүүхдийн тасалбараар 15 кг хүртэл жинтэй 40х60х80см-ээс хэтрэхгүй хэмжээтэй нэг гар тээшийг үнэ төлбөргүй авч явах эрхтэй.

12.3. Гар тээшинд зорчигчийн аяллын туршид хэрэглэх хүнсний болон хувийн хэрэгцээний эд зүйлс, ариун цэврийн хэрэглэл, ахуйн зориулалттай бараа орно.

12.4. Хорио цээр тогтоосон бүс нутгаас гар тээш тээвэрлэхийг хорио цээрийн албаны зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

12.5. Гар тээшийн бүрэн бүтэн байдлыг зорчигч өөрөө хариуцах үүрэгтэй.

12.6. Вагон болон зорчигчийн эд юмсыг гэмтээх, бохирдуулах, эвгүй үнэртэй, хортой ачаа, галт зэвсэг, галын аюултай, түргэн ба өөрөө шатах, тэсрэх, дэлбэрэх, цацраг идэвхт, идэмхий болон хордуулах бодис, мансууруулах бодис зэрэг хууль тогтоомжоор тээвэрлэхийг хориглосон зүйлс, мөн түүнчлэн түүхий мах гэх мэт түргэн муудах эд юмсыг гар тээшинд авч явахыг хориглоно.

12.7. Вагоны гар тээшний байранд багтахгүй том хэмжээний телевизор, компьютер, дуу ба дүрс бичигч зэрэг эмзэг ачааг гар тээшинд хамааруулан зорчих тасалбараар үнэ төлбөргүй галт тэргэнд авч явахыг зөвшөөрнө.

12.8. Мал эмнэлгийн улсын хяналтын дүрмээр хориглоогүй бол 2 хүртэл тооны гэрийн тэжээвэр амьтан (нохой, шувуу, муур, туулай, зараа зэрэг)-г зорчигчийн галт тэргэнд зохих хөлс, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэн тасалгаат вагонд авч явахыг зөвшөөрнө. Харин амьтан, шувууг хүүхэд зорчиж буй вагонд тээвэрлэж болохгүй.

12.9. Нохойг хошуувч, оосортойгоор бусдын аюулгүй байдлыг хангаж тээвэрлэнэ.

12.10. Бусад тэжээвэр амьтан ба шувууг хайрцаг, тор зэрэг зориулалтын саванд тээвэрлэнэ”

12.11. Тэжээвэр амьтан, шувууг зорчигчийн ба тээшийн вагонд авч явахад тээшийн тасалбар үйлдүүлж, нүүрэн талд нь "зорчигч гартаа авч явах тээш" гэсэн тэмдэглэгээ хийлгэж тээшийн тарифаар хөлсийг төлнө.

12.12. Тэжээвэр амьтан, шувууг тээшийн дагалдах бичиггүй, төлбөр хийгээгүйгээр галт тэргэнд авч орохыг хориглоно. Хэрэв орсон бол тээврийн хөлсийг нөхөн төлүүлэх бөгөөд татгалзсан тохиолдолд тээвэрлэлтийн гэрээнээс татгалзах эрхтэй. Татгалзсан шалтгааны талаар эрх бүхий этгээд акт үйлдэнэ.

13 дугаар зүйл. Гар тээш буруу тээвэрлэх

13.1. Зорчигч тогтоосон хэмжээнээс их овор, хэмжээтэй гар тээш тээвэрлэвэл суусан өртөөнөөс очих өртөө хүртэл тээврийн хөлсийг тээшийн тарифын дагуу төлүүлнэ. Зорчигч

төлбөрөөс татгалзвал тээвэрлэлтийн гэрээнээс татгалзаж цагдаагийн ажилтан бүхий өртөөнд галт тэрэгнээс буулгана. Зорчигч галт тэргэнд тээвэрлэхийг хориглосон гар тээш авч явсан нь илэрвэл төмөр замын байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон цагдаагийн ажилтанд мэдэгдэж холбогдох арга хэмжээ авна.

14 дугаар зүйл. Гар тээш хадгалах нөхцөл

14.1. Гар тээш хадгалах байр өртөө, буудалд байна. Энэ байранд зорчих тасалбарыг үл харгалзан овор хэмжээ багатай гар тээшийг хүлээн авна. Гар тээш хадгалах байрын ажиллах цагийн хуваарийг зорчигчдод үзэгдэхүйц газар байрлуулна.

14.2. Гар тээш хадгалах байранд 50 кг-аас дээшгүй жинтэй, сав, баглаа, боодолтой тээшийг байр тус бүрээр нь хүлээн авч хадгална. Харин энэ дүрмийн 11.6; 11,8-д заасан тээш болон амьтан, жигүүртэн хүлээн авахгүй. Гар тээш хадгалах байранд зорчигчийн хадгалуулахаар өгсөн тээшин дэх түргэн муудах, гэмтэх эд юмсыг төмөр замын байгууллага хариуцахгүй.

14.3. Хадгалах байранд гар тээш хүлээн авахдаа сав, баглаа, боодлын бүрэн бүтэн байдлыг шалгах ба тасалбарын үлдэх хувь дээр ачааны эзнээр нотолгоо болгон гарын үсэг зуруулна.

15 дугаар зүйл. Үнэ зарлах

15.1. Хадгалуулахаар өгөх гар тээш тус бүрт эсвэл нийтэд нь үнэ зарлаж болно. Тээшийн үнэ эргэлзээтэй байвал уул ачааны баглаа, боодлыг задлахыг эзнээс нь шаардана. Хэрэв эзэн нь задалж үзүүлэхийг эс зөвшөөрвөл уул гар тээшийг хадгалахаар хүлээж авахгүй. Ачааны эзэн тогтоосон тарифын дагуу зарласан үнэд зохих хөлсийг төлнө.

16 дугаар зүйл. Хадгалалтын хөлс төлөх

16.1. Хадгалахаар хүлээн авах гар тээш тус бүрийн зарласан үнийн дүн, хүлээн авсан огноо, цаг минут, тоо ширхэг болон гар тээшийн эзний биеийн байцаалтын тухай тэмдэглэл бүхий дагалдах бичгийг олгоно.

16.2. Гар тээшийн эзэн тээш хадгалуулсны хөлсийг тогтоосон тарифын дагуу төлнө. Хадгалуулсан гар тээшийг олгохдоо гар тээшийн эзний биеийн байцаалт болон дагалдах бичгийг шалгаж олгох ба дагалдах бичгийг хурааж авна.

17 дугаар зүйл. Гар тээш хадгалах автомат хайрцгийг ашиглах

17.1. Гар тээш хадгалах автомат хайрцгуудыг буудал дотор, зорчигчдод үйлчлэх үйлчилгээний шаардлага хангасан, гэрэлтүүлэг сайтай газар байрлуулсан байна.

17.2. Хадгалах автомат хайрцаг тус бүрийг дэс дараалан дугаарласан байна. Автомат хадгалах хайрцгийн ашиглах журмыг тод тодорхой бичиж, зорчигчдод үзэгдэхүйц газар байрлуулна.

17.3 Зорчигч тээшээ автомат хадгалах хайрцагт нууц дугаараар хадгалах ба нууц дугаарын хадгалалт, ашиглалтыг зөвхөн зорчигч өөрөө хариуцна.

17.4. Хадгалах автомат хайрцагны ашиглалтад буудлын ажилтан хяналт тавина.

17.5. Төмөр замын байгууллага тус бүр өөрийн ашиглаж байгаа хадгалах автомат хайрцагны ашиглах журмыг тогтооно.

18 дугаар зүйл. Үрэгдсэн гар тээш болон дагалдах бичгийг шийдвэрлэх

18.1. Хадгалуулахаар өгсөн гар тээш үрэгдвэл өртөө ба буудлын дарга ерөнхий маягтын дагуу акт үйлдэж, тасалбар үзүүлэгчид зарласан үнийн хэмжээгээр хохирлыг барагдуулна. Гар тээшинд үнэ зарлагдаагүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

18.2. Алга болсонд тооцогдсон гар тээш олдвол өмнө нь эзэнд нь төлсөн төлбөрөө эргүүлэн авч, гар тээшийг олгоно.

18.3. Хадгалуулсан гар тээшийн дагалдах бичгийг зорчигч үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн эд зүйл болохыг нотолсон баримт бичгийг бүрдүүлэх бөгөөд түүнийг хянан үзсэний үндсэн дээр олгож болно. Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг тээвэрлэгч өөрийн дотоод журмаар зохицуулна.

19 дугаар зүйл. Нэхэмжлээгүй гар тээшийг борлуулах

19.1. Гар тээшийг 5 хүртэлх хоногийн хугацаатайгаар хадгалах байранд хүлээн авна. Гар тээшээ 30 хоногийн дотор авахгүй тохиолдолд тээш хадгалалтын гэрээгээр тохиролцсон мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөх ба төмөр замын байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран комисс томилж, уг гар тээшийг иргэний хууль тогтоомжийн дагуу худалдан борлуулж хадгалалтын гэрээний хөлсийг нөхөн төлүүлнэ.

IY БҮЛЭГ

Тээш хүлээн авах ба тээвэрлэх нөхцөл

20 дугаар зүйл. Тээш хүлээн авах, тээвэрлэх

20.1. Тээш гэж зорчигч зорчих тасалбараа үзүүлж, аялах галт тэрэгнийхээ тээшний вагонд тээвэрлүүлэхээр хүлээлгэн өгсөн, энэ дүрмийн 19.5-д заасан нөхцөлийг хангасан эд юмсыг хэлнэ.

20.2. Зорчигчийн галт тэрэгний зогсолттой, тээш тээвэрлэлтэд нээлттэй бүх өртөө, зөрлөгт тээш хүлээн авах, тээвэрлэх, олгох ажиллагаа явагдана.

20.3. Зорчигчоос хүлээн авах тээш нь тээшийн вагоны хаалгаар чөлөөтэй багтах, ачих, буулгах, зөөвөрлөхөд хялбар бариултай, сав, баглаа, боодол нь тээвэрлэлтийн явцад тээшийн бүрэн бүтэн байдлыг найдвартай хангахаар зохих журам, зааврын дагуу бэлтгэгдсэн байвал зохино.

Задарч эвдрэхээргүй унадаг дугуй, мотоцикл, хүүхдийн тэрэг, тахир дутуу хүний тэргэнцэр зэргийг ороолт, боодолгүйгээр тээвэрлэлтэд хүлээн авч болно.

20.4. Тээшийн сав, баглаа, боодол нь бат бэх, цоож нь гэмтэлгүй байх шаардлага хангасан байна.

20.5. Нэг байр эзлэх тээш нь 75 кг-аас ихгүй байх ба нэг зорчих тасалбараар тээвэрлүүлэх тээшний нийт хэмжээ 200 кг-аас их байж болохгүй.

20.6. Бүрэн бүтэн бус сав, баглаа, боодолтой тээшийг тээвэрлэлтэд хүлээж авахгүй. Бусад тээшинд гэм хор учруулах, бохирдуулах, эвгүй үнэртэй ачаа, галт зэвсэг, галын аюултай,

түргэн ба өөрөө шатах, тэсрэх, дэлбэрэх, цацраг идэвхт, идэмхий, хордуулах болон мансууруулах бодис зэрэг хууль тогтоомжоор тээвэрлэхийг хориглосон зүйлс, мөн түүнчлэн хорио цээрийн голомтод байсан тэжээвэр амьтанг тээвэрлэхээр хүлээж авахыг хориглоно.

20.7. Зорчигчийн зорчих тасалбарт заасан өртөө хүртэл тээшийг тээвэрлэх бөгөөд хүлээн авах цэгийн байрлалаас хамаарч галт тэрэг хөдлөхөөс нэг цагаас доошгүй хугацааны өмнө тээшийг тээвэрлэлтэд хүлээн авна.

20.8. Тээвэрлэсэн тээшний сав, баглаа, боодлын илэрхий дутагдлын талаарх шаардлагыг хүлээн авсан өдөртөө, харин далд дутагдалтай холбоотой шаардлагыг ачаа хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор бичгээр гаргаагүй тохиолдолд төмөр замын байгууллага хүлээн авахгүй. Харин хагарч эвдрэх ачааны тэмдэг наасан тээшийг анхаарал болгоомжтой тээвэрлэх үүргийг төмөр замын байгууллага хариуцна.

20.9. Өртөөний тээш хүлээн авах, олгох газрын ажиллах цагийн хуваарь зорчигчдод үйлчлэх бүх боломжийг хангасан байна.

20.10. Тээшийг тухайн зорчигчийн аялах галт тэргээр илгээх ба боломжгүй тохиолдолд дараагийн галт тэргээр эхний ээлжид явуулна.

20.11. Онцгой болгоомж шаардсан тээшийг тээвэрлэлтийн гэрээ байгуулахдаа талууд техникийн нөхцөл, тээвэрлэлтийн шаардлагыг харилцан тохиролцон, зохих ачааны анхааруулах тэмдэг нааж хүлээн авна.

21 дүгээр зүйл. Тээшийн тэмдэглэл хийх, тээвэрлэлтэд бэлтгэх

21.1. Зорчигчийн тээвэрлүүлэх тээш тус бүр дээр 3х15 см-ийн хэмжээтэй цаас, картон ба даавуун наадас буюу зүүлтийг тодоор бичиж хадах үүргийг тээшийн газрын ажилтан гүйцэтгэж, зохих хөлсийг тээш илгээгчээс авна.

Наадас буюу зүүлт дээр бичигдэх зүйл:

- Тээшийн эзний овог нэр, хаяг
- Явуулах өртөөний нэр
- Хүрэх өртөөний нэр
- Тээшийн тасалбарын дугаар
- Тээшийн жин
- Байрын тоо
- Тээшийн нэр
- Илгээсэн огноо

21.2 Тээшийг тээвэрлэлтэд хүлээн авч, дагалдах бичгийг үйлдэж, тээшийн тасалбарыг зорчигчид олгох ба зорчигчийн зорчих тасалбарт "тээш" гэсэн тэмдэг дарна

21.3. Тээш хүлээлцэгч ороож боох боломжгүй унадаг дугуй, тэргэнцэр зэргийг тээшинд хүлээж авахдаа тээшийн замын хүснэгтэд тухайн эд зүйлийн серийн дугаар болон хонх, гэрэл гэх мэт эд анги нь бүрэн бүтэн эсэхийг заавал тэмдэглэж бичнэ.

22 дүгээр зүйл. Үнэ зарлах

22.1. Зорчигч тээшээ тээвэрлэлтэд хүлээлгэн өгөхдөө түүнд үнэ зарлаж болох бөгөөд зохих хөлсийг тарифын дагуу төлнө. Хэрэв хэд хэдэн тээш өгсөн бол тээш тус бүрд эсвэл

нийтэд нь үнэ зарлаж болно. Тээшийн эзний хэлсэн үнийн дүнг тээшийн тасалбарт тоо ба үсгээр бичнэ. Харин тээш тус бүрийн жин ба үнийг тоогоор бичнэ.

22.2. Төмөр замын ажилтан зорчигчийн зарласан үнийн зөв эсэхэд эргэлзвэл тээшийг задлахыг шаардаж болох ба энэ талаар маргаан гарах тохиолдолд эрх бүхий ажилтан асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв зорчигч нь тээшээ задалж үзүүлэхгүй эсвэл эрх бүхий ажилтны шийдвэрийг эс зөвшөөрвөл уг тээшийг хүлээн авахаас татгалзана.

23 дугаар зүйл. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг тээшээр тээвэрлэх

23.1. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг замдаа шилжүүлэн ачилтгүй шууд явах галт тэргэнд тээшээр тээвэрлэхээр хүлээн авна.

23.2. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг бусад тээш болон вагоныг гэмтээхгүй, бохирдуулахгүй байх боломжоор хангасан контейнер, сагс, тор, саванд тээвэрлэнэ. Энэ тор, сав нь тээвэрлэх амьтдын тоо, хэмжээнд тохирсон байх шаардлагатай бөгөөд хэт овортой байж болохгүй. Нэг байрны хэмжээ нь 50 кг-аас хэтэрч болохгүй. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг галт тэрэг хөдлөхөөс нэг цагийн өмнө тээвэрлэлтэд хүлээн авна. Мал адгуус болон зэрлэг амьтдыг тээшээр тээвэрлэхгүй. Мал адгуусыг тээшийн вагонд тээвэрлэх тохиолдолд тусгайлсан гэрээний үндсэн дээр тээвэрлэж болно.

23.3. Төмөр замын байгууллагын буруугаар ташаа илгээснээс бусад тохиолдолд гэрийн тэжээвэр амьтан, шувууг хооллох арчлах ажлыг эзэн нь хариуцна.

23.4. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг тээшээр тээвэрлэж буй галт тэрэг хүргэх ёстой өртөөнд ирмэгц тээш хүлээн авагч нь заавал хүлээн авна. Хэрэв аваагүй тохиолдолд энэ тухай үйлчлүүлэгчид утас, факс, шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэж, баримтжуулан тэмдэглэгээ хийж уул амьтан, шувууг холбогдох байгууллагад актаар хүлээлгэн өгнө.

23.5. Тээшийн дагалдах бичгээ зорчигч үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн эд зүйл болохыг нотолсон баримт бичгийг бүрдүүлэх бөгөөд түүнийг хянан үзсэний үндсэн дээр олгож болно. Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг тээвэрлэгч өөрийн дотоод журмаар зохицуулна.

23.6. 5-аас дээшгүй гэрийн тэжээвэр амьтан, шувууг мал эмнэлгийн магадлагаатай бол нэг илгээлтээр тээвэрлэж нэг илгээлтээр тээвэрлэж болно.

24 дүгээр зүйл. Ургамал, суулгац тээвэрлэх

24.1. Бусад тээшийг бохирдуулахааргүй, сав, баглаа, боодол нь тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангасан, хорио цээрийн бичигтэй бут, суулгац болон бусад ургамлыг тээшээр тээвэрлэж болно. Тээшийг тээвэрлэлтэд тухайн галт тэрэг хөдлөхөөс 2 цагийн өмнө хүлээн авна. Тээш тус бүрийн хүндийн жин 50 кг, өндөр нь 2 м-ээс хэтэрч болохгүй. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээс тээвэрлэх ургамал, суулгацыг зохих журмын дагуу хорио цээрийн албаны зөвшөөрлийг үндэслэн хүлээн авч тээвэрлэнэ.

25 дүгээр зүйл. Тээш илгээх

25.1. Зорчигч тээшээ өөр галт тэргээр илгээх тухай захиалга өгөөгүй бол уг зорчигчийн аялах галт тэргээр тээшийг явуулах ёстой ба тээвэрлэх боломжгүй бол дараагийн эхний галт тэргээр явуулна.

25.2. Тээшийг шилжүүлэн ачих нөхцөлөөр тээвэрлэлтэд хүлээн авах үед тээш илгээгч шилжүүлэн ачилтын үйлчилгээний хөлсийг хариуцах ба төмөр замын байгууллага зорчигчийн оролцоогүйгээр ачих, буулгах ажлыг гүйцэтгэнэ.

25.3. Хууль, хяналтын байгууллагын шийдвэрээр тээшийг хүргэх өртөөнөөс өөр өртөөнд саатуулагдахаар бол тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан, цагдаагийн ажилтан хамтран акт үйлдэн гарын үсэг зурж, энэ тухай тээш хүрэх өртөөнд мэдэгдэж, хүрэх өртөө нь харилцаа холбооны хэрэгслээр мэдээлж, баримтжуулан тэмдэглэгээ хийж, тээш илгээгч, хүлээн авагчид мэдэгдэнэ.

26 дугаар зүйл. Аяллын замд тээш олгох

26.1. Зорчигч аяллын замдаа тээшээ авахыг хүсвэл галт тэрэгний даргаар дамжуулан эсвэл өөрийн биеэр тээш түгээгчид урьдчилан мэдэгдэх ёстой.

а. Тээшийн вагон дахь ачааны байрлал болон өртөөн дээр галт тэрэг зогсох хугацаанд тээшийг олгох боломжтой бол түүнийг олгоод тээшийн дагалдах бичгийг зорчигчоос хурааж авна.

б. Уг дагалдах бичгийг замын хүснэгтийн хамт тээш түгээлтийн ээлжит тайланд хавсарган төмөр замын байгууллагын санхүүд явуулахаар тээш олгосон эрх бүхий ажилтанд хүлээлгэн өгнө. Ийм тохиолдолд тээш тээвэрлэгдээгүй зайн хөлсийг буцааж олгохгүй.

27 дугаар зүйл. Тээврийн хөлс төлөх

27.1. Тээш тээвэрлэх хөлсийг түүний дагалдах бичгийг үйлдэх үед хураана.

27.2. Тээшийн хүндийн жин нь дагалдах бичигт зааснаас илүү байвал аяллын замд буюу очсон өртөөнд ерөнхий маягтын акт үйлдэн тээврийн хөлсний зөрүүг зорчигчоос шаардаж авна.

28 дугаар зүйл. Хаягласан өртөөнд тээшийг хүлээн авах ба олгох

28.1. Өртөөнд ирсэн тээшийг олгохдоо тээшийн дагалдах бичгийг төмөр замын хүснэгттэй тулган тохирсон тохиолдолд хүлээн авагчид олгоно. Тээшийн хүснэгтийг тээшийн тайланд хавсарган төмөр замын харьяа холбогдох байгууллагын санхүүд явуулна.

28.2. Тээш тээвэрлэлтийн үйл ажиллагаанд нээлттэй өртөөнд тээш хүлээлцэгчид тээшийг хүлээн авах ба хүлээлгэн өгөх бөгөөд хаалттай өртөөнд тээш түгээгч нь вагоноос шууд олгоно.

28.3. Тээш нь хүрэх өртөөнд ирээгүй тохиолдолд зорчигчийн тээшийн дагалдах бичгийн ар талд "тээш ирээгүй" гэсэн тэмдэглэл хийж он, сар, өдрийг бичиж өртөөний буюу буудлын тэмдэг дарна. Тээш ирсэн тухайд уг зорчигчид мэдэгдэх хаяг, утасны дугаар болон мэдэгдэх арга байдлыг тодруулж авна.

28.4. Тээш хүргэх хугацааг эзэн нь зорчиж буй тээшийн вагон бүхий галт тэрэгний эсвэл зорчигчийн хүссэн ёсоор тээшийг илгээсэн галт тэрэгний замд явах хугацаагаар тус тус тодорхойлно. Тээшийг шилжүүлэн ачилт бүхий чиглэлээр явуулсан тохиолдолд түүнийг хүргэх хугацааг тээшийн вагон буюу зорчигчийн галт тэрэгний цагийн хуваарьт заасан хугацаан дээр шилжүүлэн ачилт бүрт тус бүр нэг хоног нэмж тодорхойлно.

28.5. Тээш ирсэн тухай мэдэгдлийг тээш хүлээн авагчид тухайн өдөр нь хаягийн дагуу харилцаа холбооны хэрэгслээр мэдэгдэн баримтжуулан тэмдэглэгээ хийж тээш хүлээн авагчид мэдэгдэнэ. Хүлээн авагчтай холбогдож чадаагүй нөхцөлд тээш илгээгчид мэдэгдэнэ. Утсаар мэдэгдэнэ. Мэдэгдлийн үйлчилгээний хөлсийг хүлээн авагч төлнө.

29 дүгээр зүйл. Тээшийн гэмтэл

28.1. Хүлээн авагч тээшийн тоо ширхэг, жин дутсан эсвэл сав, баглаа, боодол нь эвдэрсэн байхад хүлээн авахыг зөвшөөрвөл тээшийг олгож, дагалдах бичгийг тээшийн пүүлэгчид өгөх ба замын хүснэгтийн ард "өөрөө авахыг хүсэв" гэж тэмдэглэл хийж хүлээн авагчаар гарын үсэг зуруулна. Бусад тохиолдолд дутагдал, эвдрэлийн тухай түүний овог нэр, хаяг, үнэ зарласан байвал үнийн дүн зэргийг тусгасан ерөнхий маягтын дагуу акт тогтоох ба тээврийн акт үйлдэн хуулбарыг түүнд өгнө.

29.2. Хэрэв тээшийн дутагдал төмөр замын байгууллагын буруугаас болсон бол хохирлыг тээш тус бүрийн зарласан үнийн дагуу, хэрэв зарласан нэг үнэтэй байвал дутсан тээшийн жинтэй шууд (пропорционал) хамаарлаар, хэрэв зорчигч тээшиндээ үнэ зарлаагүй бол дутагдсан хүндийн хэмжээгээр хохирлыг 1,0 кг тутмыг 2,0 швейцар франкаар тооцож тухайн өдрийн Монгол банкны тогтоосон тооцооны ханшаар төгрөгт шилжүүлэн бодож төмөр замын байгууллага нөхөн төлнө.

29.3. Хэрэв тээш алга болсонд тооцогдож, эзэнд нь нөхөн төлбөр төлсний дараа уул тээш чанар, хэмжээ алдагдаагүй олдвол нөхөн төлбөр, үйлчилгээний хөлсийг суутгаж, тээшийг эзэнд нь хүлээлгэн өгнө.

30 дугаар зүйл. Тээш болон тээшийн тасалбарыг үрэгдүүлэх

30.1. Зорчигч тээш хүргэх хугацаа (энэ дүрмийн 27.4-д тодорхойлсон) өнгөрснөөс хойш 21 хоногийн дотор уул өртөөнд тээш ирээгүй бол (эрх бүхий байгууллагын шийдвэрээр тээшийг саатуулснаас бусад тохиолдолд) хохирлоо нөхөн төлүүлэх шаардлага бичгээр гаргах эрхтэй. Хохирлыг энэхүү дүрмийн 28.2-т заасны дагуу эзэнд нь төлж холбогдох бичиг баримтыг бүрдүүлнэ.

30.2. Зорчигч тээшийн дагалдах бичгээ үрэгдүүлсэн тохиолдолд түүний бичгэн мэдүүлэг болон бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн уул тээш тухайн зорчигчийнх мөн болохыг нотлох баталгааг гаргуулж тээшийг олгож болно. Өртөө, буудлын холбогдох ажилтан нь дагалдах бичиггүйгээр тээш олгосон шалтгааны талаар тээшийн замын хүснэгтэд тэмдэглэл хийж үлдээнэ.

31 дугаар зүйл. Тээшийг дахин илгээх

31.1. Тээш нь тээшийн замын хүснэгтээс салж тээвэрлэгдсэн, тээврийн бичиг баримтад заагдсанаас өөр өртөөнд хүргэгдсэн ба тээш нь зорчигчийн хамт хүрэх өртөөнд ирээгүй, түүний хүрэх хугацаа өнгөрсөн тохиолдолд уг зөрчлийг илрүүлсэн өртөө нь энэ тухай бүх өртөөнд болон Зорчигч тээврийн асуудал эрхэлсэн төмөр замын байгууллагад мэдэгдэнэ. Зорчигч тээврийн асуудал эрхэлсэн төмөр замын байгууллага эрэл хийх ба тээш олдсон тохиолдолд тухайн өртөөнд дахин илгээлт хийх шийдвэр гаргана. Шийдвэр авсан өртөө ба буудлын дарга тээшийн дагалдах бичиг болон замын хүснэгтийн ар талд "тээш зохих хугацаандаа ирээгүй учир тээшийг дахин илгээх тухай мэдэгдлийг хүлээн авлаа" гэсэн тэмдэглэл хийж он, сар, өдөртэй тэмдэг дарна.

31.2. Дахин илгээсэн тээш өртөөнд ирмэгц өртөө ба буудлын даргын нэрийн өмнөөс тээшийн хүлээн авагчийн нэр дээр бичиг баримт (ачаа тээшээр) үйлдэж илгээнэ. Тээшийн шинэчилсэн замын хүснэгтэд түүний анхны илгээлтийн дугаарыг заана.

Дахин илгээсэн тээшийг замын шинэчилсэн хүснэгтээр явуулж, харин тээшийн дагалдах бичиг, дахин илгээх тухай мэдэгдэл зэргийг дагалдах бичгийн үлдэх хувьтай хавсарган тайлангийн хамт төмөр замын байгууллагын санхүүд явуулна.

31.3. Тээш ирсэн ба түүнийг дахин илгээсэн тухай анх хүргэх ёстой байсан өртөө, дахин илгээсэн цаг, нөхөн хүргэх дагалдах бичгийн дугаар зэргийг заасан бичгээр тээш хүлээн авагчид мэдэгдэнэ. Шинээр хүргэсэн өртөө нь уг тээшийг үнэгүйгээр олгох ба анх илгээсэн тээшийн дагалдах бичгийг тээш хүлээн авагчаас хурааж авна. Дээрхээс бусад тохиолдолд тээшийг дахин илгээж болохгүй.

32 дугаар бүлэг. Тээшийг хадгалах

32.1. Өртөөнд ирүүлсэн тээшийг ирсэн өдрөөс эхлэн тээш хүлээн авагчид олгох хүртэлх хугацаанд хадгалсны хөлсийг төмөр замын байгууллагын даргын баталсан үнэлгээний дагуу зорчигчоос авна.

33 дугаар бүлэг. Нэхэмжлээгүй тээшийг борлуулах

33.1. Зорчигч, байгууллага, аж ахуйн нэгж тээшээ 30 хоногийн дотор авахгүй бол төмөр замын байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагаас оролцуулсан комиссыг томилж, уг ажлын хэсэг тээшийг борлуулах арга хэмжээг авна. Тээшийг худалдан борлуулснаас хойш 6 сарын дотор тээш хүлээн авагч илэрч нэхэмжилвэл борлуулалтын орлогоос төмөр замын байгууллагын ажил, үйлчилгээний хөлсийг суутгаад үлдэх хэсгийг нэхэмжлэгчид тээшийн дагалдах бичгийг үндэслэн олгоно.

Ү БҮЛЭГ

Ачаан тээш хүлээн авах ба тээвэрлэх нөхцөл

34 дүгээр бүлэг. Ачаан тээш хүлээн авах, тээвэрлэх

34.1. Ачаан тээш гэж илгээгчээс зорчих тасалбар шаардалгүйгээр захиалгын маягтыг бөглүүлж, хүлээн авсан энэ дүрмийн 33.4-д заасан нөхцөлийг хангасан эд юмсыг хэлнэ.

34.2. Ачаан тээшийн сав, баглаа, боодол нь тэдгээрийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцөлийг хангасан байна.

34.3. Ачаан тээш хүлээн авах, явуулах, олгох үйл ажиллагаа ачаан тээш тээвэрлэхэд нээлттэй өртөөнд хийгдэнэ.

34.4. Нэг ачаан тээшийн хүндийн жин нь 10 кг-аас бага, 100 кг-аас их байж болохгүй, тээш ачих буулгах техник хэрэгсэлтэй өртөөнд нэг ачаан тээшийн хүндийн жин 75 кг-аас 165 кг хүртэл байж болно. Гурван хэмжээсийн нийлбэр нь 500 см-ээс ихгүй, ачааг ачаан тээш тээвэрлэлтийн тарифаар тооцно.

34.5. Дараах ачаан тээшийг эхний ээлжид тээвэрлэнэ. Үүнд:

- Сонин, бусад өдөр тутмын тогтмол хэвлэл
- Түргэн муудах бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн

- Зөвшөөрөгдсөн гэрийн тэжээвэр амьтан, шувуу
- Гэрийн эд хогшил (замдаа шилжүүлэн ачилттай хүлээн авч болно)
- Шарил

34.6. Түргэн муудах хүнсний бүх төрлийн бүтээгдэхүүнийг тээшийн вагонд тээвэрлэхээр хүлээн авахдаа түүнийг тээвэрлэх хугацаа, зайг гэмтэж муудахгүй тээвэрлэгдэх боломжтой эсэхийг тооцож хүлээн авна. Жилийн дулааны болон хүйтний улирлыг дараах байдлаар тооцно. 5 дугаар сарын 01-ээс 9 дүгээр сарын 30-ыг хүртэлх хугацааг дулааны, 10 дугаар сарын 01-нээс 4 дүгээр сарын 30-ыг хүйтний улирал гэнэ.

34.7. Дулааны улиралд ирсэн ачаан тээшийг төмөр замын байгууллага 6 цагаас дээш хадгалахгүй.

34.8. Түргэн муудах ачааг ачаан тээшээр тээвэрлэхэд галт тэрэг хөдлөхөөс 2 цагийн өмнө хүлээн авна.

34.9. Хаяг нь тодорхой нөхцөлд түргэн муудах ачааг тогтоосон хугацаанд нь авах талаар хүлээн авагчид мэдэгдэх арга хэмжээг өртөө ба буудал мөн ачаа илгээгч аль алин нь хариуцна.

34.10. Түргэн муудах ачаан тээш нь гэрээт хугацаанд хүргэгдсэн боловч төмөр замаас үл хамаарах шалтгаанаар шинж чанар муудсан тохиолдолд тээвэрлэгч гэм буруугүй болохоо нотолж, хариуцлагаас чөлөөлөгдөнө.

34.11.Тээвэрлэлтэд хүлээж авсан ачаан тээш нь гадна үзлэгээр ямар нэгэн гэмтэл учраагүй, анхааруулах тэмдэггүй атлаа дотор нь хялбар муудах зүйлс (мах, сүү, ногоо, жимс г.м.) хагарч эвдрэх хэврэг ачаа (шил, шаазан эдлэл, телевизор г.м.) нь гэмтсэн байвал уул хохирлыг төмөр зам тээвэрлэгч хариуцахгүй.

35 дүгээр зүйл. Тээвэрлэлтэд хүлээн авах

35.1. Төмөр замын байгууллага ачаан тээшийн сав, баглаа, боодол тээвэрлэлтийн шаардлага хангасан эсэхийг шалгасны дараа ачаа илгээгч захиалгын маягтыг зааврын дагуу бөглүүлж, захиалгыг өртөө ба буудлын даргад өгнө. Үүнд:

35.1.1. сав, баглаа, боодлын тоо, төрөл, хүндийн жин

35.1.2. ачааны нэр, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тэмдэг, тэмдэглэгээ

35.1.3. илгээсэн өртөө, огноо

35.1.4. хүргэх өртөө, огноо

35.1.5. зарласан үнэ

35.1.6. тухайн барааг худалдан авсан үнэ

35.1.7. илгээгчийн овог нэр, хаяг, регистрийн дугаар

35.1.8. хүлээн авагчийн овог нэр, хаяг, харилцаа холбооны хэрэгсэл, регистрийн дугаар

35.1.9. хуульд заасан бусад нөхцөл

Өртөө, буудал нь ачаан тээшийн илгээгчээс сав баглаа, боодлын шалган, зөвшөөрөгдсөн ачаан тээш мөн эсэхийг тогтоож, явуулах он, сар, өдөр, цаг, галт тэргийг тодорхой болсны дараа илгээгчээр захиалгын маягтыг бөглүүлж, маягтын үнийг төлүүлж, тээвэрлэлтэд хүлээн авна.

35.2. Захиалгыг үндэслэн зохих журмаар тээвэрлэлтийн бичиг баримт үйлдэнэ. Өртөө ба буудлын дарга ачаан тээшийг явуулах огноо, цаг минут, галт тэргийг тогтоосны дараа ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээн авч, төлбөр төлсөн дагалдах бичгийг ачаан тээш илгээгчид олгоно.

Ачаан тээшийн нэр зөв эсэх талаар эргэлзээ гарсан тохиолдолд төмөр замын байгууллага ачааны сав, баглаа, боодлыг задлах шаардлага тавих эрхтэй. Ачаа тээшийг задалж үзэхийг илгээгч эс зөвшөөрвөл түүнийг тээвэрлэлтэд хүлээж авахгүй.

35.3. Илгээгч нь тогтоогдсон журмын дагуу ачаан тээшиндээ заавал үнэ зарлана. Тээврийн хөлс ба үнэ зарласан хураамжийг тарифт заагдсаны дагуу төлнө.

35.4. Ачаан тээшийг замаас дахин илгээх болон замд тавьж олгохыг зөвшөөрөхгүй.

35.5. Ачаан тээшийг тухайн зорчигчийн явах галт тэрэгний тээшийн вагоноор явуулах боломжгүй (багтаагүй зэрэг бусад шалтгаанаар) тохиолдолд тухайн чиглэлийн дараагийн галт тэргээр явуулж болно.

Зорчигч ачаан тээшиндээ үнэ зарлахаас татгалзвал эсвэл зорчигчийн үнэ зарласан байдал барааны нэр төрөл, тоо ширхэг нь бодит үнэтэй тохирохгүй байвал явуулах өртөө ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээн авахаас татгалзана.

35.6. Тээш, ачаан тээшийн үйлчилгээ явуулдаггүй жижиг өртөө, зөрлөг хоорондын замын хэсгүүдээс явуулж буй ачаан тээшийг тээшийн вагонд ажиллах тээш түгээгч хүлээн авах ба үнэ зарлалт ачилт, шилжүүлэн ачилт, буулгалт зэрэг нэмэгдэл хураамжийг илгээгч хариуцна.

36 дугаар зүйл. Ачаан тээшийг тавьж олгох

36.1. Ачаан тээш ирсэн өртөөнд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан ачаан тээш харилцаа холбооны хэрэгслээр мэдэгдэж баримтжуулан тэмдэглэгээ хийж хүлээн авагчтай холбогдож чадаагүй тохиолдолд илгээгчид мэдэгдэнэ. Мэдэгдэх үйлчилгээ үзүүлсэн хөлсийг хүлээн авагчаас авна.

36.2. Албан байгууллага, компанийн нэр дээр ирсэн ачаан тээшийг хүлээн авах этгээд нь уул байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэг, тэмдэг бүхий итгэмжлэлийг иргэний үнэмлэх эсвэл бусад биеийн байцаалтын хамт шалгуулан замын хүснэгтийн ар талд гарын үсэг зурж, ачаан тээшийг хүлээн авна. Ачаан тээш хүлээн авагчаас итгэмжлэлийг авч үлдэнэ. Тодорхой хүний хаягаар ирсэн ачаан тээшийг хүлээн авагчид эсвэл түүний итгэмжилсэн этгээдэд иргэний үнэмлэх эсвэл бусад нотлох баримтыг үзэж олгох ба замын хүснэгтийн ар талд тэмдэглэл хийж гарын үсэг авна. Ачаан тээш байнга ирдэг байгууллагын хүлээн авагч байнгын итгэмжлэх бичигтэй байх шаардлагатай ба түүгээр ачаан тээшийг олгоно.

37 дугаар зүйл. Ачаан тээшийг хадгалах, цэгцлэх

37.1. Ачаан тээшийн жинг шалгасны үнийг төмөр замын байгууллагын даргын тогтоосон тарифын дагуу ачаа илгээгч эсвэл ачаа хүлээн авагчаас ав

37.2. Ачаан тээшийн өртөөнд хадгалсан хөлсийг тээвэрлэн ирсэн өдрөөс хүлээлгэн өгсөн өдөр хүртэлх хугацаагаар тооцож тогтоосон тарифын дагуу төлүүлнэ.

37.3. Ачаан тээшээ 30 хоногийн дотор авахгүй бол төмөр замын байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагаас оролцуулсан комиссыг томилж, уг комисс ачаан тээшийг борлуулах шийдвэр гаргаж зохион байгуулна.

37.4. Төмөр замын байгууллагын буруугаас ачаан тээш үрэгдэх, дутах мөн түүнчлэн хүргэх хугацаа хожимдуулсны хариуцлагыг энэ дүрмийн дагуу төмөр замын байгууллага хүлээнэ. Хэрэв ачаан тээш алга болсон бол хохирлыг зарласан үнийн хэмжээгээр төлнө.

ҮИ БҮЛЭГ

Тээвэрлэлтэд тавих хяналт

38 дугаар зүйл. Тээвэрлэлтэд хяналт тавих

38.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдал, тээвэрлэлттэй холбоотой ажил, үйлчилгээний чанар хууль тогтоомж, стандартын шаардлагад хангаж буй эсэхэд Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч болон дотоодын хяналтын байцаагч хяналт тавина. Хяналтын байцаагч нь доорх зүйлийг шалгана:

- зорчигчийн зорчих тасалбар
- галт тэрэгний дарга, мастер, вагоны үйлчлэгчийн гүйцэтгэх үүргийн биелэлт
- зорчигчийн гар тээш энэ дүрмээр тогтоосон тоо, хэмжээнд байгаа эсэх
- зорчих ба тээшийн дагалдах бичиг зохих ёсоор үйлдэгдсэн эсэх
- зорчих тасалбар худалдах газрын үйл ажиллагаа, зохион байгуулалт
- вагоны сул чөлөөтэй байрыг хэрхэн зохицуулсан, түүний тухай мэдээг дараагийн өртөөнд дамжуулсан эсэх
- албаны, түрээсийн болон бусад албан байгууллагуудын вагоныг зориулалтын ажилд хэрэглэж байгаа эсэх

Хяналт тавих эрх бүхий этгээд нь өртөө, буудал ба галт тэргэнд тасалбар худалдах ажлын зохион байгуулалт, зорчигчдын үйлчилгээнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

38.2. Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч болон төмөр замын байгууллагын эрх бүхий албан тушаалтан галт тэргэнд шалгалт хийх эрхтэй.

38.3. Шалгалтын үед зорчих тасалбаргүй эсвэл хөнгөлөлттэй тасалбараар зорчиж буй зорчигчийн насны хязгаарт эргэлзвэл холбогдох бүх бичиг баримтыг шалгаж, үнэн зөвийг тогтоох шаардлагатай.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ҮИИ БҮЛЭГ

Зорчигч тээвэрлэлтийн тариф ба нэмэгдлийн төрөл

39 дүгээр зүйл. Зорчигч тээвэрлэлтийн тариф, нэмэгдэл

39.1. Тээвэрлэлтийн шууд ба орон нутгийн харилцааны бүх төрлийн галт тэргээр зорчих нийтийн тариф зорчигчдод үйлчилнэ.

39.2. Зорчигч тээврийн хөлсийг зохих тарифын үнэлгээ ба түүний жинхэнэ зайгаар тооцно. Тарифын зайг тухайн зорчигч явах зорчигчийн галт тэрэгний чиглэлийн дагуу бодно.

39.3. Тээвэрлэлтийн тарифын зай болон өртөөний гүйцэтгэх үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын баталсан тарифын бодлогоор тодорхойлно.

39.4. Зорчигчийн галт тэргэнд зорчих тасалбарын үнэ нь төмөр замын байгууллагын даргын баталсан орон нутгийн харилцааны зорчигч тээврийн тарифаар тодорхойлогдох ба бусад ажил, үйлчилгээний үнэлгээг тухайн төмөр замын байгууллага тусад нь тогтооно.

39.5. Хөнгөлөлттэй зорчих тасалбар (5-12нас)-ыг орон нутгийн харилцааны зорчигч тээврийн тарифын вагоны төрлөөс хамаарсан зохих баганад заасан тарифаар бичнэ.

39.6. Хүн суух зориулалтаар тоногдсон ачааны вагонд зорчигчдыг тээвэрлэхэд нийтийн вагоны тарифыг 50 хувиар хямдруулан хэрэглэнэ.

40 дүгээр зүйл. Зорчигчийн даатгалын хураамж

40.1. Зорчигчоос гэнэтийн ослын даатгалын хураамжийг төмөр зам байгууллагаас даатгалын компанитай байгуулсан гэрээнд заасан хэмжээгээр хураана.

41 дүгээр зүйл. Зорчих тасалбаргүй аялах

41.1. Зорчих тасалбар худалдах газартай өртөөнөөс тасалбаргүйгээр эсвэл зөрчилтэй тасалбараар зорчиж байгаа зорчигч үнэ төлбөргүй авч орсон тээшинд нэмэгдэлтэй тарифаар галт тэргэнд тасалбар бичнэ. Нэмэгдлийн хэмжээг төмөр замын байгууллагын дарга тогтооно.

42 дугаар зүйл. Унтлагын байрны нэмэгдэл

42.1. Унтлагын байртай вагонд зорчигч нь тээврийн хөлснөөс гадна унтлагын байр ашигласны нэмэгдэл хөлсийг тогтоогдсон тарифын дагуу төлнө.

42.2. Унтлагын байртай вагонд байр эзэлж зорчих 5-12 хүртэлх насны хүүхдэд насанд хүрсэн хүний нэгэн адил нэмэгдэл хөлс төлнө. Ингэхдээ дүрмийн 2.5.5-т заасан тохиолдолд нэмэгдэл хөлсийг 1 унтлагын байрны тарифаар тооцон авна.

43 дугаар зүйл. Тасалгааны нэмэгдэл

43.1. Тасалгаат унтлагын вагонд зорчих зорчигч нь тээврийн хөлс ба унтлагын байрны нэмэгдэл, тасалгаа эзэмшсэний нэмэгдлийг тус тус төлнө.

43.2. Тасалгаатай вагонд 5-12 хүртэлх насны хүүхэд тусдаа унтлагын байр эзэлж зорчиход насанд хүрсэн хүний нэгэн адил тасалгааны нэмэгдэл төлнө. 5-12 хүртэлх насны

хүүхэд тусдаа унтлагын байр эзлэлгүй насанд хүрсэн хүний хамт нэг байранд зорчих тохиолдолд тасалгааны нэмэгдэл төлөхгүй.

44 дүгээр зүйл. Хурдны нэмэгдэл

44.1. Хурдан галт тэргээр зорчих зорчигч нь зорчих тасалбарын хөлснөөс гадна хурдны нэмэгдэл төлнө.

ҮИИ БҮЛЭГ

Тээш, ачаан тээш тээвэрлэлтийн тариф ба нэмэгдлийн төрөл

45 дугаар зүйл. Тээш, ачаан тээш тээвэрлэлтийн тариф, нэмэгдэл

45.1. Нийтийн тээш тээвэрлэлтийн тариф нь байнгын ашиглалттай, тээш тээвэрлэлтэд нээлттэй төмөр замын бүх шугамд хэрэглэгдэнэ.

45.2. Тээшийн вагонд тээш, ачаан тээш тээвэрлэхэд төмөр замын байгууллагын даргын баталсан тариф, нэмэгдлийг мөрдөнө.

46 дугаар зүйл. Тээш тээвэрлэлтийн хөлс төлөх журам

46.1. Тээшийн тооцооны хамгийн бага хүндийн жинг 10 кг-аар тогтоох ба түүнээс дээших 5 кг тутамд тогтоосон тарифаар төлбөр хураана. Үечилсэн хэмжилтийн 5 кг-д хүрэхгүй тээшийг бүхэлдэж 5 кг-аар тооцно. Тээшийн тасалбарын үнийг тогтоож авна.

46.2. Тээшийн вагоноор тээвэрлүүлэх тээшийн хүндийн жинг түүний төрөл, сав, баглаа, боодлыг үл харгалзан зөвхөн жинхэнэ хүндийн жингийн хэмжээгээр нь тооцож тээврийн хөлсийг авна.

47 дугаар зүйл. Ачаан тээш тээвэрлэлтийн хөлс төлөх журам

47.1. Ачаан тээш тээвэрлэлтийн тарифын зайг зорчигчийн тээш тээвэрлэлтийн зайг тооцохтой нэгэн адилаар зорчигчийн галт тэрэгний аяллын чиглэлээр эрх бүхий байгууллагын баталсан тарифын бодлогоор тодорхойлно.

47.2. Ачаан тээшийн тооцооны хамгийн бага хүндийн жинг 20 кг-аар тогтоох ба түүнээс дээших 5 кг тутамд тогтоосон тарифаар төлбөр хураана. Үечилсэн хэмжилтийн 5 кг-д хүрэхгүй тээшийг бүхэлдэж 5 кг-аар тооцно.

48 дугаар зүйл. Үнэ зарласан төлбөр

48.1. Тээш болон ачаан тээшийн зарласан үнийн хэмжээнд тохируулан төмөр замын байгууллагын даргын тогтоосон үнэ зарласны төлбөрийг тээш, ачаан тээш илгээгчээс авна.

49 дүгээр зүйл. Тээш, ачаан тээшийн цэгцлэлтийн төлбөр

49.1. Тээш, ачаан тээш илгээгчид захиалгын маягт олгох ба пайз, наадас олгосны төлбөрийг авна.

50 дугаар зүйл. Ачаан тээш ирсэн тухай мэдэгдэх

50.1. Ачаан тээш ирсэн тухай хүлээн авагчид холбооны хэрэгслээр мэдэгдэж баримтжуулан тэмдэглэгээ хийж төлбөрийг ачаа хүлээн авагчаас авна.

51 дүгээр зүйл. Бичгэн магадлагаа

51.1. Лавлах бичгэн магадлагаа олгохдоо байгууллагын нэр, хаяг, тэмдэг болон эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, лавлагаа олгосон огноо, дугаарыг тодорхой заасан байх ба үйлчлүүлэгчээс зохих төлбөрийг авна.

52 дугаар зүйл. Ачаа зөөгч ажиллуулсны төлбөр

52.1. Зорчигчийн гар тээш, тээшийг буудлын дэргэдэх нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, хүлээлгийн танхим зэрэгт хүргэх зөөгч ажиллуулсны төлбөрийг тогтоосон тарифын дагуу авна.

53 дугаар зүйл. Бусад үйлчилгээний төлбөр

53.1. Дамжин өнгөрөх зорчигчийг буудалд байрлуулах, халуун ус, бусад үйлчилгээгээр үйлчилсний төлбөрийг авна.

IX БҮЛЭГ

Бусад үйлчилгээний төлбөр

54 дүгээр зүйл. Цагаан хэрэглэлийн төлбөр

54.1. Зорчигчийн галт тэргээр зорчсон зорчигчид тавьж өгсөн цагаан хэрэглэлийн төлбөрийг авна.

55 дугаар зүйл. Гар тээш хадгалсны төлбөр

55.1. Зорчигч эд юмсаа өртөө, буудлын гар тээш хадгалах байранд болон автомат хадгаламжид хадгалуулсны төлбөрийг төлнө.

55.2. Үнэ зарласан гар тээш, мөн түүнчлэн олдсон эд юмсыг хадгалсны төлбөрийг тухайн эд юмсын эзэн төлнө.

56 дугаар зүйл. Зорчих тасалбарыг урьдчилан худалдсаны төлбөр

56.1. Зорчих тасалбарын урьдчилсан захиалгад үнийн хөнгөлөлт үзүүлэх, нэмэлт хөлс авах эсэхийг төмөр замын байгууллага өөрөө тогтооно.

57 дугаар зүйл. Зорчих тасалбар хүргэсний хөлс

57.1. Зорчигчийн зорчих тасалбарыг гэрт нь хүргэж өгөх үйлчилгээний төлбөрийг тогтоосон журмын дагуу авна.

X БҮЛЭГ

Зарим зорчигчийг тээвэрлэх онцгой нөхцөл

58 дугаар зүйл. Зарим зорчигчийг тээвэрлэх онцгой нөхцөл

58.1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид олон улсын чанартай уралдаан тэмцээн, аялал жуулчлал болон бусад арга хэмжээнд зохион байгуулалттайгаар хэсэг бүлгээр олон улсын зорчигчийн галт тэргээр зорчиход хөнгөлөлт үзүүлж болно. Хөнгөлөх хэмжээг төмөр замын байгууллага тогтооно.

58.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох, аялал болон хүүхдийн зусланд амрахаар орон нутгийн зорчигчийн галт тэргээр зорчиход нийтийн вагоны тасалбарын үнийн дүнгээс хөнгөлөлт үзүүлж болно. Хөнгөлөх хэмжээг төмөр замын байгууллага тогтооно

Өртөө, буудлын дарга хүссэн байрыг галт тэрэг явахаас нэг хоногийн өмнө олгоно. Захиалгат байрыг галт тэрэг явах цагаас 1 цаг 30 минутын өмнө хүртэл хадгална. Захиалгат нэр, албан байгууллагын хаягийг заасан байна.

58.3. Нийтээр амрах баяр болон оюутан, сурагчдын улирлын амралтын үеэр зохион байгуулалттайгаар хэсэг бүлгээр зорчих тохиолдолд төмөр замын байгууллагын шийдвэрээр зорчих тасалбарын үнийг хямдруулж болно.

58.4. Энэ хөнгөлөлт нь гадаадын жуулчин, аялагчид хамаарахгүй.

59 дүгээр зүйл. Жуулчдыг тээвэрлэх

59.1. Гадаад болон дотоодын жуулчид монгол орноор аялал жуулчлалаар явах тохиолдолд шууд ба орон нутгийн харилцааны вагонд зорчихдоо тасалбар худалдах газарт урьдчилсан захиалга өгч үйлчлүүлнэ.

59.2. Олон улсын галт тэргээр зорчих жуулчид төмөр замын олон улсын тасалбар худалдах газарт урьдчилан захиалга өгч үйлчлүүлнэ.

59.3. Захиалгат жуулчдын зорчих тасалбар, түүний үнэ нь дотоодын болон олон улсын гэсэн ялгавартайгаар тогтоосон үнэ ба журмын дагуу гүйцэтгэгдэнэ.

59.4. Гадаадын аялагч - жуулчид, тэдний тээш, ачаан тээшийг орон нутгийн галт тэргээр (тусгай захиалгат вагонд) тээвэрлэхэд тээврийн хөлсийг нь төмөр замын олон улсын суудлын тарифт зарласан хэмжээг аялах зайд дүйцүүлэн тооцож авна.

59.5. Төлбөрийг төгрөгөөр хийх нөхцөлд тухайн үеийн Монгол банкны албан ёсны ханшаар тооцож авна.

59.6. Олон улсын байгууллага, гадаадын жуулчдын хэрэгцээнд вагон түрээслэх бол төмөр замын байгууллагын баталсан үнэ тарифаар тооцно.

59.7. Төмөр замаар тээвэрлэх шууданг тусгай гэрээг үндэслэн гүйцэтгэж тээврийн төлбөрийг гэрээнд тусгагдсан журмаар авна.

58.8. Шуудангийн вагонд шуудангаас бусад ачааг төмөр замын бичиг баримтгүйгээр ачсан байвал тээврийн бүх зардлыг ачаан тээшийн тарифаар тооцох бөгөөд гэрээт байгууллага төлбөрийг төмөр замын байгууллагад төлнө.

60 дугаар зүйл. Буфет ба вагон-ресторан явуулах

60.1. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд залгах вагон-ресторан, буфетийн ажиллах нөхцөл, тэдгээрийн ажилтны зорчих тухай харилцааг гэрээгээр зохицуулна.

61 дүгээр зүйл. Ачаатай вагон тээвэрлэх

61.1. Зорчигчийн галт тэргэнд ачааны вагон залгаж тээш, ачаан тээш тээвэрлэх тохиолдолд тээш, ачаан тээш тээвэрлэх тарифт үнэлгээгээр зохицуулна.

62 дугаар зүйл. Шарил тээвэрлэх

62.1. Авсалсан шарилыг ачааны болон зорчигчийн галт тэргээр тусад нь вагонд тээвэрлэж болох бөгөөд шарил тээвэрлүүлэгч засаг захиргаа ба эмнэлгийн байгууллагын зөвшөөрөл, магадлагааг явуулах өртөөнд үзүүлнэ. Дээрх бичиг баримт нь тээврийн бичиг баримтын хамтаар очих өртөөн дэх хүлээн авагчид очно. Шарилыг сайн гагнасан төмөр авсанд буюу давирхайдсан модон хайрцагт хийж доторх хоосон зайг дүүргэх материал (үртэс, нүүрс, хүхэр, шохой зэрэг)-аар чигжсэнийг шалган хүлээн авч тээвэрлэнэ.

62.2. Хэрэв тээшийн ба шуудангийн вагоноор шарилыг тээвэрлэвэл тээвэрлэх зардлыг ачаан тээшийн тарифын үнэлгээ, 300 кг-аар тооцож төлбөрийг авна.

62.3. Тээшийн ба шуудангийн вагоноор чандар тээвэрлэх тохиолдолд ачаан тээшийн тарифын үнэлгээ, 100 кг-аар тооцож, төлбөрийг авна.

62.4. Шарилыг дагалдаж хүн заавал явна. Хэрэв дагалдагч нь ямар нэг шалтгаанаар галт тэрэгнээс хоцорвол шарилыг саатуулах шалтгаан болохгүй. Дагалдагч нь бусад зорчигчийн нэгэн адил зорчих тасалбар худалдан авч зорчино.

63 дугаар зүйл. Албан тээвэрлэлт

63.1. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд албаны вагон холбох захиалгыг албан бичгээр авч, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

63.2. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн дэх албаны вагоноор зорчигчид зорчих тасалбартай байхаас гадна тээштэй бол холбогдох бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Албаны вагонд ачаа тээвэрлэх асуудлыг төмөр замын байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэх бөгөөд ачаанд ачаан тээшийн тарифаар төлбөрийг төлнө.

63.3. Албаны вагонд зорчих журам зөрчвөл шалгагч нь илэрсэн зөрчилд акт үйлдэнэ. Акт (протокол)-ыг төмөр замын байгууллагын санхүүгээр дамжуулан төмөр замын байгууллагын дарга ба албаны вагон захиалан авсан байгууллагын харьяалах газарт явуулна.

64 дүгээр зүйл. Хувийн эзэмшлийн вагоноор зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх

64.1. Зорчигчийн ба ачааны галт тэрэгний бүрэлдэхүүнд хувийн эзэмшлийн вагон явах тохиолдолд төмөр замын байгууллага вагоны эзэмшигчтэй гэрээ байгуулна.

64.2. Хувийн эзэмшлийн вагоныг ачааны, зорчигчийн ба хурдан галт тэргэнд залгасан байдлаар вагоны гүйлтийн төлбөрийг ялгавартай тогтооно.

64.3. Хувийн эзэмшлийн вагоныг тусгай зүтгүүрээр эсвэл вагоныг дагалдсан нэмэгдэл зүтгүүртэй явуулах тохиолдолд зүтгүүрийн гүйцэтгэсэн гол км-ээр төлбөрийг тогтоож авна.

65 дугаар зүйл. Түрээсийн вагонд зорчих

65.1. Зорчигчийн вагоныг түрээсээр ашиглуулах тохиолдолд түрээслэгчтэй вагон түрээслэх гэрээ байгуулж мөрдөнө.

65.2. Вагон түрээслэх үнэлгээ, зорчигчийн болон тээшийн вагоны км тутамд ногдох гүйлтийн тарифыг төмөр замын байгууллагын даргын тушаалаар баталж мөрдөнө.

65.3.Түрээслэгчийн хүсэлтээр тусгай зүтгүүрээр түрээсийн вагоныг тээвэрлэх тохиолдолд төмөр замын байгууллагын даргын баталсан 1 зүтгүүр км-ийн үнэлгээг тээвэрлэлтийн зайд тохируулан тооцож нэмж төлнө

65.4.Түрээслэгчийн хүсэлтээр түрээсийн вагоныг хурдан галт тэргэнд холбосон тохиолдолд тээврийн хөлсийг тодорхой хувиар нэмэгдүүлэн тооцно

65.5.Түрээсийн вагон хоногийг түрээслэх вагоныг аялалд бэлдсэн хугацаа, аяллын хугацаа, вагоныг төмөр замд буцаан хүлээлгэж өгөх бэлтгэл ажлын хугацааны нийлбэрээр тодорхойлогдоно. Бүтэн хоног хүрэхгүй хугацааг бүтэн хоногоор тооцон авна.

XI БҮЛЭГ

Дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

66 дугаар зүйл. Тээвэрлэгч, зорчигчийн хүлээх эрх, үүрэг

66.1. Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрмийг үндэс болгон төмөр замын байгууллага нь зорчигчийн өмнө, зорчигч нь төмөр замын байгууллагын өмнө харилцан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

а. Төмөр замын ажилтнууд энэ дүрэмд заасан хэм хэмжээг баримтлан эрх үүргээ шударгаар хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

б. Энэ дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн төмөр замын байгууллагын ажилтанд хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасанд тооцон хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулах ба энэ нь хуульд зааснаас бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

в. Энэ дүрмээр зохицуулсан харилцаанд оролцогч гадны байгууллага, иргэд, зорчигчтой холбоотой зөрчил дутагдлыг энэ дүрэм болон бусад хууль тогтоомжийн заалтын дагуу шийдвэрлэнэ.

66.2. Төмөр замын байгууллага зорчигчийг ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлж, зорьсон өртөөнд цаг хугацаанд нь хүргэх үүрэгтэй.

66.3. Төмөр замын байгууллага нь зорчигчийн тээш ба ачаан тээшийг хүлээж авснаас эхлэн олгох хүртэл тогтоосон журмын дагуу тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

66.4. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

66.5. Зорчигч тогтоосон хэмжээнээс илүү гар тээш тээвэрлэвэл тээшийн тарифаар тээврийн төлбөр авна.

66.6. Төмөр замын байгууллага тээш хүргэх хугацаа хожимдуулсны нөхөн төлбөрийг очих өртөөн дээр үйлдсэн актыг үндэслэн төлнө.

ХИИ БҮЛЭГ

Маргаан шийдвэрлэх

67 дугаар зүйл. Олон нийтийн хэв журам сахих

67.1. Зорчигч нь төмөр замын тээврийн хэрэгсэл болон буудлын эд хогшилд ариг гамтай хандан олон нийтийн хэв журмыг чанд сахиж, төмөр замын байгууллагад мөрдөгдөж буй дүрмийн талаар мэдээллийн самбар, орон нутгийн болон үндэсний шинжтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн дүрмийг биелүүлэх үүрэгтэй.

67.2. Зорчигч энэ дүрмийн 67.1 заалтыг зөрчсөн тохиолдолд галт тэрэгний ба буудлын дарга, цагдаагийн ажилтан асуудлыг шийдвэрлэнэ.

68 дугаар зүйл. Маргааныг шийдвэрлэх

68.1. Албан үүргээ гүйцэтгэж буй төмөр замын ажилтан болон зорчигчийн хооронд гарсан маргаан, үл ойлголцлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

68.1.1. Өртөөн дээр бол өртөө буюу буудлын дарга, шаардлагатай бол цагдаагийн ажилтны тусламжтайгаар

68.1.2. Галт тэрэгний аялал явцад бол галт тэрэгний дарга, мастер эсвэл галт тэрэгний байцаагч, шаардлагатай бол галт тэргэнд ажил үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн ажилтны оролцоотойгоор

68.2. Үйлчилгээтэй холбоотой тухайн нөхцөлд шийдвэрлэх боломжгүй асуудлыг харьяалах дээд шатны байгууллагад нь хандаж шийдвэрлүүлнэ.

69 дүгээр зүйл. Мартсан болон алдсан эд юмс

69.1. Төмөр замын зурвас газар буюу галт тэргэнд гээгдсэн эд юмс олдвол тухай бүрд нь түүний байдлыг тодорхойлж акт үйлдэнэ. Хэрэв эд юмс нь галт тэргэн дотроос олдсон бол тухайн вагоны үйлчлэгчийг байлцуулан галт тэрэгний дарга, өртөөн дээрээс олдсон бол өртөө ба буудлын дарга эд юмсыг олсон этгээдийг байлцуулан акт үйлдэж, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

69.2. Эд юмс нь өртөө буюу эргэлтийн өртөөнд ирсэн галт тэргэн дотроос эсвэл тус өртөөнд ирэх хоорондын замаас олдсон бол түүнийг тусгай дэвтэрт бүртгэж холбогдох ажилтан тэмдэглэл хөтөлж тээвэрлэгчийн эрх бүхий ажилтанд хүлээлгэн өгнө. Хүлээн авсан олдсон эд юмсад тэмдэглэл хөтөлж, дэс дугаар бүхий пайз зүүнэ. Олдсон эд юмс нь боодол, хайрцаг, шуудай, чемодан зэрэг тус тусдаа сав, баглаатай байвал тус бүрийг ломбодно.

69.3 Зорчигчийн гээгдүүлсэн эд юмс (түргэн муудах, гэмтэх зүйлээс бусад)-ыг 30 хоног хадгалсны дараа энэ дүрэмд заасны дагуу холбогдох ажилтан тэмдэглэл хөтөлж борлуулна. Гээгдүүлсэн эд юмс дотор үнэт эдлэл болон үнэт цаас, бичиг баримт байвал түүнийг цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.

69.4. Гээгдсэн эд юмсыг авахаар нэхэмжлэгч этгээд нь эд юмсынхаа шинж чанар, хэлбэр, өнгө, дүрс, тоо ширхгийг тодорхой баримтаар өргөдөл хүсэлт гаргаж, мөн түүнчлэн онгойлгох түлхүүрийг үзүүлэх зэргээр нотлох ёстой. Гээгдсэн эд юмсын эзэн болох нь батлагдвал тэр этгээдэд хүлээлгэн өгнө. Гээгдсэн эд юмсыг холбогдох байгууллагад

шилжүүлсэн байвал эзэнд нь олгох тухай мэдэгдлийг өртөө (буудал)-ний дарга бичгээр явуулна. Эзэн нь эд юмсаа авахдаа тээвэрлэлт, хадгалалт, зарлуулсан зэрэгт гарсан зардлыг төмөр замын байгууллагад төлөх ба өөрийн тодорхой хаяг, харилцаа холбооны хэрэгсэл, регистрийг тэмдэглүүлж, гарын үсэг үлдээнэ. Хадгалалт, тээвэрлэлтийн төлбөрийг тээшийн тарифаар тооцож авна.

69.5. Зорчигч эд юмсаа вагонд орхисноо галт тэрэгнээс буусны дараа өөрөө мэдвэл тэр даруй өртөө ба буудлын даргад мэдэгдэх ёстой. Өртөө буюу буудлын дарга энэ тухай зорчигчийн бичгэн мэдэгдлийг үндэслэн галт тэрэгний дарга буюу эргэлтийн өртөө (буудал)-ний даргад уг зорчигч сууж явсан вагон, байрын дугаар, орхисон эд юмсын дүрс хэлбэр, хааш нь ирүүлэх зэргийг заасан цахилгаан явуулна. Уул эд юмсыг эзэнд нь хүргэж ирүүлэхтэй холбогдож гарсан бүх зардлыг эд юмсын эзэн хариуцан төлнө.

--oOo--